



Г ХАЛХГОЛ СУМЫН МОНГОЛ АРДЫН 7  
НАМЫН ХОРООНЫ ДАРГА  
Ц.НАСАНХҮҮ ТАНАА

ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000. Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг  
ЗДТГ-ны II байр, Утас/Факс: 7058-4203

2020.08.14 № 588

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г Хандивын тайлангийн дүгнэлт 7

Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит сонгуульд оролцох Халхгол сумын Монгол ардын намаас ирүүлсэн хандивын тайланг Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хянан баталгаажуулж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох Халхгол сумын Монгол ардын нам нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.6, 25.4.6-д заасны дагуу иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайлангаа мөн хуулийн 37 дугаар зүйлийн 37.7-д заасны дагуу Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлж, дүгнэлт гаргуулах үүргийг хүлээнэ.

Хандивыг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, мөн хуулийн 16 дугаар зүйл, Сангийн сайд 2017 оны 386 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн бус байгууллагын санхүүгийн тайлангийн маягт, заавар”ын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайландаа тусгах үүргийг улс төрийн нам хүлээнэ.

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар нь Төрийн аудитын тухай хууль болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн заасны дагуу сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит сонгуульд оролцох улс төрийн намд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргана. Намаас дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн хандивын тайланд тусгагдаагүй хандивыг хянан баталгаажуулахгүй бөгөөд түүнээс үүсэх үр дагавар, хариуцлагыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар хүлээхгүй болно.

**Дүгнэлтийн үндэслэл**

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит сонгуульд оролцох Халхгол сумын Монгол ардын намд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг нийцлийн аудитын стандарт MNS 6817-8:2020, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны A/47 тоот тушаалаар батлагдсан зааврыг баримтлан Улс төрийн намын тухай хуулийн 18 дугаар зүйлтэй нийцэж буй эсэхийг дэмжих нотлох баримт, дүн дүгнэлтийн үндсэн дээр хянан баталгаажуулж, дүгнэлт гаргасан болно.

**Дүгнэлт**

Халхгол сумын Монгол ардын нам нь 2020 оны ээлжит сонгуулийн жилийн 06 дугаар сарын 01-ний өдрөөс өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд хандив хүлээн аваагүй, хандивын орлого бүртгэгдэж тайлагнаагүй байна.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.БОЛОРТУУЛ

011020751